



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 9 дүгээр сарын 13-ны
өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

(Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2019 оны 196 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 220, 48 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 294 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 299 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны 87 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон)

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Б.Хурцад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЭРДЭНЭБАТ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Ж.МӨНХБАТ

o/ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1-д заасан төрийн нууцад хамааруулсан мэдээллээс гадна эрүүл мэндийн салбарын хэмжээнд дараах мэдээллийг төрийн нууцад хамааруулна:

№	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл		Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	
1	Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл (тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэл)		+	20
2	Төрийн дээд, өндөр хэмжээний айлчлалын бэлтгэл ажилтай холбоотой бусад яамд, холбогдох байгууллага, албан тушаалтантай харилцсан албан бичиг		+	20
3	Төрийн нууцад хамаарах асуудлаар олон улсын хурал, зөвлөгөөн, чуулганд оролцох төлөөлөгчдийн ажлын чиглэл, удирдамж		+	Хуульд өөрөөр заагаагүй бол хурал, чуулган дуустал
4	Эрүүл мэндийн яамны дайчилгааны даалгавар, төлөвлөгөө		+	20
5	Хуулиар төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлээр хамгаалуулж байгаа албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл		+	20
6	Эрүүл мэндийн салбарын онц чухал объектын байршил, олгосон газрын нэр зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл		+	20
7	Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан, технологийн ололт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилт, угсралт, төслийн ажил, технологийн тухай мэдээлэл		+	20
8	Төрийн нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг, холбогдох мэдээлэл		+	20
9	Төрийн нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг, бусад тээгч		+	20
10	Төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл		+	20